

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/3/НА-СТА-ТӨА**

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг:
gansukh.audit@gmail.com

Аудитор: Б.Алтанцэцэг

Утас: 99016193 Цахим хаяг: altaa_6116@yahoo.com

Гэрээгээр гүйцэтгэсэн: Чадварлаг аудит ХХК-ийн

Захирал: Д.Рэнцэнханд

Утас: 99200034 Цахим хаяг: chadvarlagAudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллагын үйл ажилагаа.....	9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
4. Аудитын тайлан	9
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Дотоод хяналт.....	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
4.4 Материаллаг байдал.....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
8. Аудитын илрүүлэлт.....	15
8.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
8.2 Төлбөрийн акт.....	Error! Bookmark not defined.
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж.....	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2022-03-21 № 330
танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн 2021 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

/АОУС 701-ийн шаардлагын дагуу аудитын гол асуудал бүрийн тайлбар/

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

015030661

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Auditin gazar\baiguullagiiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/мян.төгрөг/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.0	0.0
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.0	0.0
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	400,762.5	529,138.9
1.1.2	Дансны авлага	41,507.3	41,507.3
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0.0	3,697.6
1.1.4	Бусад авлага	17,385.8	11,294.4
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.0	0.0
1.1.6	Бараа материал	199,577.4	210,686.7
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.0	0.0
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.0	0.0
1.1.10		0.0	0.0
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	659,233.0	796,324.9
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,033,526.1	1,037,548.1
1.2.2	Биет бус хөрөнгө	490,210.0	490,674.5
1.2.3	Биологийн хөрөнгө	0.0	0.0
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.0	0.0
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.0	0.0
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.0	0.0
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.0	0.0
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0
1.2.9		0.0	0.0
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,523,736.1	1,528,222.6
1.3	Нийт хөрөнгийн дүн	2,182,969.1	2,324,547.5
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.0	0.0
2.1	ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
2.1.1.1	Дансны өглөг	36,687.5	107,092.0
2.1.1.2	Цалингийн өглөг	0.0	0.0
2.1.1.3	Татварын өр	24,422.2	9,192.4
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.0	0.0
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.0	0.0
2.1.1.6	Хүүний өглөг	0.0	0.0
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.0	0.0
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.0	0.0
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	0.0	0.0
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.0	0.0
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	61,109.7	116,284.4
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0

2.1.2.1	Урт хугацаат зээл	0.0	0.0
2.1.2.2	Нөөц /ер төлбөр/	0.0	0.0
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.0	0.0
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	160,001.5	160,001.5
2.1.2.5		0.0	0.0
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	160,001.5	160,001.5
2.2	Өр төлбөрийн нийт дүн	221,111.2	276,285.9
	ЭЗДИЙН ӨМЧ	0.0	0.0
2.3	Өмч	1,257,949.0	1,265,365.7
2.3.1	-төрийн	1,257,949.0	1,265,365.7
2.3.2	-хувийн	0.0	0.0
2.3.3	-хувьцаат	0.0	0.0
2.3.4	Халаасны хувьцаа	0.0	0.0
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.0	0.0
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	358,891.1	358,891.1
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.0	0.0
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.0	0.0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	345,017.8	424,004.8
2.3.10		0.0	0.0
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,961,857.9	2,048,261.6
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	2,182,969.1	2,324,547.5

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөр дугаар	Үзүүлэлт	/мян.төгрөг/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,874,922.3	2,343,350.2
2	Борлуулалтын өртөг	2,502,953.3	1,959,429.1
3	Нийт ашиг (алдагдал)	371,969.0	383,921.1
4	Түрээсийн орлого	0.0	0.0
5	Хүүний орлого	0.0	0.0
6	Ногдол ашгийн орлого	0.0	0.0
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.0	0.0
8	Бусад орлого	3,415.5	357.0
9	Борлуулалт, маркетингийн зардал	46,308.8	57,453.7
10	Ерөнхий ба удирдлагын зардал	206,169.1	216,118.5
11	Санхүүгийн зардал	0.0	0.0
12	Бусад зардал	38,504.0	22,942.6
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	93.2	0.0
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.0	0.0
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.0	0.0
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.0	0.0
17	Бусад ашиг (алдагдал)	0.0	0.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	84,495.8	87,763.3
19	Орлогын татварын зардал	8,449.6	8,776.3

20	Татварын дараахь ашиг (алдагдал)	76,046.2	78,987.0
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.0	0.0
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	76,046.2	78,987.0
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.0	0.0
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	0.0
23.3	Бусад олз (гарз)	0.0	0.0
24	Орлогын нийт дүн	76,046.2	78,987.0
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.0	0.0

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/мян.төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,353,541.8	358,891.1	268,971.6	1,981,404.5
1	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0
2	Залруулсан үлдэгдэл	1,353,541.8	358,891.1	268,971.6	1,981,404.5
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	76,046.2	76,046.2
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	-95,592.8	0.0	0.0	-95,592.8
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,257,949.0	358,891.1	345,017.8	1,961,857.9
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0
2	Залруулсан үлдэгдэл	1,257,949.0	358,891.1	345,017.8	1,961,857.9
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	78,987.0	78,987.0
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	7,416.7	0.0	0.0	7,416.7
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,265,365.7	358,891.1	424,004.8	2,048,261.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөр дугаар	Үзүүлэлт	/мян.төгрөг/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн	3,290,100.8	2,672,969.0
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.0	0.0
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.0	0.0
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.0	0.0
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.0	0.0
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.0	0.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,290,100.8	2,672,969.0
1.2	Мөнгөн зарлагын дүн	3,187,242.1	2,544,592.6
1.2.1	Ажиллагчдад төлсөн	369,150.5	340,826.0
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	156,182.0	148,979.7
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,204,209.4	1,507,121.1
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.0	0.0
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.0	0.0
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.0	0.0
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	289,981.9	180,486.9
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.0	0.0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	167,718.3	367,178.9
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	102,858.7	128,376.4
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
2.1	Мөнгөн орлогын дүн	0.0	0.0
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.0	0.0
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.0	0.0
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.0	0.0
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.0	0.0
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.0	0.0
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.0	0.0
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.0	0.0
2.1.8		0.0	0.0
2.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	0.0
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0

2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	0.0
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.0	0.0
2.2.6		0.0	0.0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	0.0
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
3.1	Мөнгөн орлогын дүн	0.0	0.0
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.0	0.0
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.0	0.0
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.0	0.0
3.1.4		0.0	0.0
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	0.0
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.0	0.0
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.0	0.0
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.0	0.0
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.0	0.0
3.2.5		0.0	0.0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	0.0
4	Валютын ханшийн зөрүү	0.0	0.0
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	102,858.7	128,376.4
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	297,903.8	400,762.5
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	400,762.5	529,138.9

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	хэмжих нэгж	2020 он гүйцэтгэл	2021 он		Зөрүү	Хувь
				Зорилт	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	мян.төг	2,842,700.00	2,100,000.00	2,343,350.20	243,350.20	111.59
	Улсын чанартай зам засварын ажил	мян.төг	2,008,459.60	1,900,000.00	1,616,144.60	(283,855.40)	85.06
	Орон нутгийн чанартай зам засварын ажил	мян.төг	834,240.40	200,000.00	620,614.00	420,614.00	310.31
2	Нийт зардал	мян.төг	2,785,846.00	2,037,000.00	2,255,568.90	218,568.90	110.73
	Үүнээс: Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	286,197.30	281,043.40	273,572.20	(7,471.20)	97.34
3	Татвар төлөхийн өмнөх ашиг	мян.төг	56,854.00	63,000.00	87,763.30	24,763.30	139.31
4	Цэвэр ашиг	мян.төг	51,168.60	56,700.00	78,987.00	22,287.00	139.31
5	Төсвийн нийт төлбөр	мян.төг	352,500.00	281,460.00	341,156.70	59,696.70	121.21

6	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	10,233.70	11,340.00	17,552.70	6,212.70	154.79
7	Нийт ажиллагсдын тоо	хүн	47.00	47	45	(2.00)	95.74
8	Цалингийн сан	мян.төг	547,656.00	514,796.60	521,182.00	6,385.40	101.24
9	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	971.00	912.70	965.10	52.40	105.74
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.98	0.97	0.96	(0.01)	98.97
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	205,000.00	165,000.00	164,800.00	(200.00)	99.88
12	Нийт авлага	мян.төг	94,000.00	93,000.00	56,499.30	(36,500.70)	60.75
13	Нийт өглөг	мян.төг	238,501.50	236,001.50	276,286.00	40,284.50	117.07
	Үүнээс Богино хугацаат өглөг	мян.төг	78,500.00	76,000.00	116,284.40	40,284.40	153.01
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	160,001.50	160,001.50	160,001.50	-	100.00
14	Хөдөлмөрийн бүтээмж	мян.төг	60,482.90	44680.8	52074.5	7393.7	116.548

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК гэсэн статустай байна. Компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг ТӨБЗГ хэрэгжүүлнэ гэж Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн дүрэмд тусгасан байна.

Компанийн үндсэн зорилт нь төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан. Зам засвар арчлалтын гэрээний дагуу Өвөрхангай аймгийн хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино гэж тусгасан байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг автозамын засвар арчлалт, шугамын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж, хариуцсан авто зам авто байгууламжийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж гарсан эвдрэл гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Өвөрхангай АЗЗА ТӨХК нь Төрийн Өмчийн Хорооны 2006 оны 173 тоот тогтоолыг үндэслэн байгуулж, ТӨБЗГазрын 2012 оны 06 сарын 14-ны өдрийн 274 тоот тогтоолоор Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн дүрмийг шинэчлэн баталж бүртгүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..." гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг ТӨБЗГазраас томилж байгаа нь Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1-д .Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө.гэсэн заалттай нийцэж байна.

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 27.5 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд тус компани нь Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах ба бүртгэх данснаас хасах журмын дагуу үйл ажиллагаа явуулж 2021 онд ТӨБЗГазрын 2021 оны 572 тоот тогтоолоор нийт 3 нэрийн 7.7 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж газрыг нь бүртгэлд хэвээр нь үлдээх арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу болон ТӨБЗГазраас Өмчийн Бодлого Зохицуулалтын газраас 2021 оны А-1/354 тоот албан даалгавар гарсны дагуу Өвөрхангай АЗЗА ТӨХК нь дараах ажлуудыг хийхээр төлөвлөгөө гарган батлуулж ажилласан байна.Үүнд: 2021 компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинд тусгагдсан зайлшгүй зардлаас бусад зардлыг гаргахгүй байх,шинээр ажлын чиг үүрэг албан тушаал орон тоо нэмэхгүй байх, албан конторын тавилга болон автомашин авахгүй байх, тэмдэглэлт ой болон спортын уралдаан тэмцээн зохион, аялал зугаалга зохион байгуулахгүй байх зэргийг тусган ажилласнаар албан томилолт, сургалт,цахилгаан дулаан, шагнал урамшуулал түрээсийн зардлуудаас нийт 40.7 сая төгрөг хэмнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлтүүд ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлтийн нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	400762.5	529138.9	128376.4
Дансны авлага	41507.3	41507.3	0
Татвар НДШ-ийн авлага	0	3697.6	3697.6
Бусад авлага	17385.8	11294.4	-6091.4
Бараа материал	199,577.40	210,686.70	11,109.30
Эргэлтийн хөрөнгийн дүн	659,233.00	792,627.30	133,394.30
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	1,033,526.10	1,037,548.10	4,022.00
Биет бус хөрөнгө	490,210.00	490,674.50	464.50
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,182,969.10	2,324,547.50	141,578.40
Өр төлбөрийн нийт дүн	221,111.20	276,285.90	55,174.70
Эздийн өмчийн дүн	1,961,857.90	2,048,261.60	86,403.70
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,182,969.10	2,324,547.50	141,578.40

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 10.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна. Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 518.8 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 41,507 мянган төгрөг болсон нь өмнөх оны авлага Ванчинсайн Илч ХХК-иас 13,484.5 мянган төгрөг, Хүлгийн дээд ХХК-иас 19,272.3 мянган төгрөг, Үлэмж хурд ХХК-иас 3,150.0 мянган төгрөг, Өндөрсант хайрхан ХХК-иас 5,600.5 мянган төгрөгийн он дамжсан авлага байна.

Бусад авлага нэмэгдсэн өртгийн авлага 3,697.6 мянган төгрөг, ажиллагсдаас авах урьдчилгааны үлдэгдэл 6,091.3 мянган төгрөг байна. Энэ нь зарим ажиллагсдад өндөр хэмжээгээр цалингийн урьдчилгаа олгосноос он дамжсан авлага үүсэхэд нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 210,686.7 мянган төгрөг буюу 11,109.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь зарим материалын үнэ өссөнтэй холбоотой. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй эвдэрсэн 49 нэр төрлийн 18343.3 мянган төгрөгийн бараа

материалыг Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн өмч хамгаалах комиссын 2021 оны 12 сарын 29-ны өдрийн шийдвэрээр акталж данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,037,548.1 мянган төгрөг байна. Үүнд: Шинээр 205,205.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 572 тоот тогтоолоор 7749.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 158 дугаар тогтоолоор нийт 40,405.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 32,988.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй экскаваторыг Хархорин АЗЗА ТӨХК-иас балансаас баланст шилжүүлжээ. Биет бус хөрөнгө 464.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн программ хангамж худалдаж авснаас шалтгаалжээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 276,285.9 мянган төгрөг байна. Үүнд: Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 116.2 сая төгрөгийн өр төлбөр байна. Үүнд: Тодтунгалаг тэмдэг ХХК -д 40,000.0 мянган төгрөг, Од Арвайхээр хурд ХХК-д 18780,0 мянган төгрөг, Хасгарьд констракшн ХХК-д 37,500.0 мянган төгрөг, ААНОАТатварын өр 7345.7 мянган төгрөг, Цалин хөлсний орлогын татварын өр 1,846.7 мянган төгрөг байна. Өр төлбөр нэмэгдсэн шалтгаан нь зарим компаниудын гүйцэтгэсэн ажлын чанараас шалтгаалан төлбөрийг хийгээгүйгээс шалтгаалжээ.

Урт хугацаат өр нь ЗТБХБЯмнаас авсан урт хугацаат өглөг 160,001.5 мянган төгрөг нь төлөх хугацаа болоогүй өглөг байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлыг гарсан тухайн үед нь мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, удирдлагын зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад үйл ажиллагааны зардал 5612.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос орлого буурсан нь шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт ажиллагсдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, түүхий эд материал, тээвэр, шатахуун, сэлбэг хэрэгсэл, хоол хүнс хээрийн томилолт, хөдөлмөрийн болон техникийн түрээс зэрэг зардлуудыг хамруулсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу ӨВ АЗЗА ТӨХК захирал нь байгууллагын үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө боловсруулж зохих байгууллагаар батлуулж биелэлтийг хангах хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын 2020 оны 12 сарын 08-ны өдрийн 617 тоот тогтоолоор "Өвөрхангай АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө"-г баталсан байна. Тайлант онд нийт орлогыг 2,100,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,037,000.0 мянган төгрөгөөр, ашгийг 63,000.00 мянган төгрөгөөр тогтоосон байна. Гүйцэтгэлээр 2,343,350.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,255,586.9 мянган төгрөгийн зардал гарган, 78,987.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь

автозамын байгууламж барих, засвар арчлалтын ажил, автозамын тэмдэг тэмдэглэгээний ажил, бусад гэрээгээр гүйцэтгэсэн ажлуудын орлогоос бүрджээ.

Тайлант онд нийт орлогын гүйцэтгэл 2,343,350.20 мянган төгрөг болж төлөвлөснөөс 243,350.2 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар давж биелсэн нь Орон нутгийн чанартай зам засварын ажил 620,614.00 мянган төгрөгөөр буюу 210.0 хувиар илүү гүйцэтгэлтэй байсан.

Нийт зардлын гүйцэтгэл 2,255,568.90 мянган төгрөг болж төлөвлөснөөс 218,568.90 мянган төгрөг буюу 10,7 хувиар илүү байна.Энэ нь орлого өссөнтэй холбоотойгоор гол нөлөө үзүүлсэн байна нь нөлөөлж байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 165000.0 мянган төгрөгийн ажилд өөрийн эх үүсвэрээс 164800.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг /алдагдал/ 78,987.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 22287.0 мянган төгрөгөөр илүү байгаа нь төлөвлөсөн зорилтоос илүү ажил гүйцэтгэж орлого нэмэгдсэн нь нөлөөлж байна.

ТӨБЗГазрын 2021 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А 1/1111 тоот шийдвэрийн дагуу тайлант онд төрийн өмчийн ногдол ашигт 11,340.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 17,552.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансанд холбоотой өгсөн зөвлөмжүүдийг Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 28-наас 03 сарын 05-ны хооронд Чадварлаг аудит ХХК-ийн аудитор Б.Алтанцэцэг гүйцэтгэж, хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн тусгасан болно.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн. Тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/12 тоот тушаалаар Дотоод хяналтын комиссыг шинэчлэн 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна. Дотоод хяналтын нэгжийн ажиллах журам, төлөвлөгөө, гарах зардлыг баталж тайланг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай АЗЗА ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 2,255,586.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 33,833.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 25,375.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өвөрхангай АЗЗА ТӨХК нь тайлант онд нийт сая төгрөгийн 172 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 26.2 сая төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: шилэн дансны тухай хуулийн зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

5.2 бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант хугацаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжид томоохон өөрчлөлт гараагүй Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17.11, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах заалтуудад тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлан онд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 18.6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 10.2 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс албан шаардлага 100 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	18600.0	1	18600.0	0	0	0
Зөвлөмж	2	10207.9	2	10207.9	0	0	0
Нийт дүн	3	28807.9	3	28807.9	0	0	0

/мянган төгрөг/

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын ажилтнуудад цалингийн урьдчилгаа тодорхой тогтоосон журамгүй олон сараар урьдчилж олгосноос үүдэн оны эцэст төлж дуусаагүй авлага үүсгэж байгаад анхаарах

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 26.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

8.3 Албан шаардлага

1. ТӨБЗГазраас ирсэн шийдвэрийн дагуу шилжиж ирсэн Самсунг маркийн экскаваторын элэгдлийн зардлыг 5.1 сая төгрөгөөр илүү тооцон зардалд бичсэн.

2. Санхүүгийн тайлангаарх 6 харилцагчийн 9.8 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээлэлд нийт 172 мэдээлэл оруулахаас 166 мэдээлэл оруулж 4 мэдээ хугацаа хожимдуулсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хуульд заасан хугацаанд байршуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.


9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акг. албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Загруулга		Акг		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж														
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн											
Санхүүгийн тайлангийн асуудлаар																													
1	Өвөрхангай АЗЗА ТӨХК	ӨВА-2022/3/НА-СТА-ТӨА	ТӨБЗ Газраас ирсэн шийдвэрийн дагуу шилжиж ирсэн Самсунг маркийн экскаваторын элэгдлийн зардлыг 5058.7 мянган төгрөгөөр илүү тооцон зардалд бичсэн	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дэх заалт, ААНОАТ-ын тухай хуулийн 17.11 дэх заалтыг мөрдөж ажиллах	1	5058.7					1	5058.7																	
2	Өвөрхангай АЗЗА ТӨХК	ӨВА-2022/3/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайланд харилцагчийн 9794.9 төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, 20.2.5 дахь заалтуудын хэрэгжүүлж ажиллах	1	9794.9					1	9794.9																	
ДҮН					2	14853.6					2	14853.6																	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалтсан нийцлийн асуудал																													
3	Өвөрхангай АЗЗА ТӨХК	ӨВА-2022/3/НА-СТА-ТӨА			1												1												
ДҮН															3	14853.6													
НИЙТ ДҮН															2	14853.6													

АУДИТЫН ТАЙЛАМГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О. БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д. ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  Б. БАЛТАНЦЭЦЭГ

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР